


БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН
ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГА Ж.ГАНБОЛД



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ГРАУНД
ГОЛЬФИЙН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Ч.НАРАНБААТАР

ХАМТРАН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ГЭРЭЭ

2018 оны 05 дугаар
сарын 14-ны өдөр

№

Улаанбаатар
хот

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Граунд гольф”-ийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнийг Улаанбаатар хотноо зохион байгуулахтай холбогдуулан :

Нэг талаас Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороог /цаашид “Захиалагч” гэх/-ыг төлөөлж хэлтсийн дарга А.Болдмаа нөгөө талаас Монголын Үндэсний Граунд гольфийн холбоог /“Гүйцэтгэгч” гэх/-ийг төлөөлж санхүүч Д.Даваадулам нар энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг заалт:

- 1.1 Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Граунд гольф”-ийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнийг Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хороо, Монголын Үндэсний Граунд гольфийн холбоо хамтран зохион байгуулна.
- 1.2 Нийслэлийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/373 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг хамтран зохион байгуулна.
- 1.3 Батлагдсан төсвийг Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооноос Монголын Үндэсний Граунд гольфийн холбооны дансанд шилжүүлнэ.
- 1.4 Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Граунд гольф”-ийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 06 дугаар сарын 29.30-ны өдрүүдэд явагдана.

Хоёр. Гэрээний хугацаа :

- 2.1 Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Граунд гольф”-ийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах гэрээний хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.
- 2.2 Тэмцээний нийт зардал 9.400.000 / есөн сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн дотор Монголын Үндэсний Граунд гольфийн холбооны хаан банканд дахь 5031995628 тоот дансанд шилжүүлнэ.

Гурав. Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны эрх үүрэг :

3.1 Ажлын хэсгийн бүрэлдэхүүний 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар Нийслэлийн Засаг даргын орлогч, Ажлын хэсгийн ахлагч Ш.Анхмаагаас өгөгдсөн үүрэг чиглэлийн ажлыг зохион байгуулуулах, хяналт тавьж гүйцэтгэлийг тухай бүрд нь тайлагнана. Үүнд :

а. Граунд гольфийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд дүүрэг тус бүрээс 30 хүний бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлэн оролцуулж, баг тамирчдад дэмжлэг үзүүлэн ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт,

б. Тэмцээнд ажиллах шүүгчдийн бүрэлдэхүүнийг сонгож сургалт зохион байгуулахыг Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хороо Монголын мастеруудын биеийн тамир спортын хороонд,

в. ГГАТАШТ-ийг хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэст,

г. ГГАТАШТ-ний үед нийтийн хэв журам, аюулгүй байдлыг ханган ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн газарт,

д. Автомашины хөдөлгөөнд зохицуулалт хийж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн албаны Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газарт,

е. Тэмцээний үеэр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт,

ё. Баг тамирчдын тэмцээний талбайд хүргэх, авах, автобус унааны асуудлыг зохицуулахад дэмжлэг үзүүлэхийг Нийслэлийн Тээврийн газарт,

з. Тэмцээн зохион байгуулагдах зориулалтын талбай, зүлэг ногоог тэгшлэх ажлыг зохион байгуулахыг Хот тохижилтийн газар ОНӨҮГ-т тус тус үүрэг болгосон байна.

3.2 Дээрхи байгууллагуудын гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал гомдлын шаардлага гаргах эрхтэй.

3.3 Тэмцээнтэй холбогдох бичиг, баримт материалуудыг шаардаж авах эрхтэй.

3.4 Тэмцээн зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн тайланг МҮГГХ-оос хүлээн авах

3.5 МҮГГХ-нд тэмцээний зардлыг саадгүй шилжүүлэх үүрэгтэй.

Дөрөв. Монголын Үндэсний Граунд гольфийн холбооны эрх үүрэг :

4.1 Гэрээнд заасан ажлыг хамтран зохион байгуулж тогтоосон хугацаанд чанартай хийж гүйцэтгэх үүрэгтэй.

4.2 Тэмцээн дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан гүйцэтгэсэн ажилтай холбогдох баримт бичиг, материалуудыг бүрдүүлж тайлан мэдээг Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хороонд хүргүүлэх үүрэгтэй.

- 4.3 Тэмцээний зардлыг бүрэн гүйцэт авах эрхтэй.
4.4 Тамирчдыг бүртгэж Мандатыг олгох үүрэгтэй.
4.5 Гадаадын тамирчпын байр, хоолны асуудлыг хариуцах үүрэгтэй.
4.6 Тэмцээний холбогдолтой асуудлыг тухай бүрд нь шийдвэрлүүлэх эрхтэй.

Тав. Талуудын хүлээх хариуцлага :

5.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хүлээх үүрэгтэй.

Зургаа. Бусад заалт :

- 6.1 Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. /Эсвэл хүчин төгөлдөр болох өдрийг тохиролцож болно./
6.2 Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
6.3 Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл /шүүх, арбитр/-аар шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам :

- 7.1 Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгддэг талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
7.2 Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжинд заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож хугацаанаас нь өмнө цуцалж болно.

Найм. Нэмэлт нөхцөл :

.....
.....

ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ :


ЗАХИАЛАГЧ :

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ХОРООГ ТӨЛӨӨЛЖ
ХЭЛТСИЙН ДАРГА
А.Болдмаа



ГҮЙЦЭТГЭГЧ :

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ГРАУНД
ГОЛЬФИЙН ХОЛБООГ ТӨЛӨӨЛЖ
САНХҮҮЧ
Д.Даваадулам



Холбогдох утас : 99178373 9 , 99130719